



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 167

Баян-Өндөр сум

**Мөнгөн дэмжлэг үзүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/741 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхий, тив, олон улсын тэмцээнд оролцох тамирчдад зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мөнгөн дэмжлэгт зарцуулагдах 3,000,000 (гурав сая) төгрөгийг зохих журмын дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  ДЭЛГЭРБАЯР



Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн
10/16/24...дугаар тушаалын хавсралт



ТЭМЦЭЭН, УРАЛДААНЫ МӨНГӨН ДЭМЖЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ
ТӨСӨВ

№	Шийдвэрийн нэр, дугаар, огноо	Спортын төрөл	Зардлын нэр	Хүний тоо		Нэг бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
				Тамирчин	Дасгалжулагч		
1	2	3	4	5	6	7	8
1.	Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 09- ний өдрийн А/741 дүгээр захирамж	Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдах дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд	замын зардал	2	1	500,000	1,500,000
		Хөвсгөл аймагт зохион байгуулагдах 21 аймгийн хөл бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд	замын зардал	баг		1,500,000	1,500,000
	Төсвийн нийт дүн						3,000,000

----oOo----

